



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 101

Алтай

Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.-ын "б" дахь заалт, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 24-ний 70 дугаар тогтоолоор баталсан "Хоггүй цэвэр Алтай" хөтөлбөр, 2014 оны 12 дугаар сарын 10-ны 84 дүгээр тогтоолоор баталсан "Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалт, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Сумын Засаг дарга нарт:

1. Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс хэрэгжилт удаашралтай байгаа зорилт, арга хэмжээг жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах;
2. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах арга хэмжээг зохион байгуулах;
3. Дээрх хөтөлбөрүүдийг иргэд, олон нийтэд сурталчилан таниулж, тэдний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;
4. Орчны бохирдолоос үүсэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга замын талаар сургалт сурталчилгааг тогтмол явуулах;
5. Хог хаягдлын тухай болон агаарын тухай хууль тогтоомжид заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үүргийн хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;

Хоёр. Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

1. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, оролцогч талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах;

02 000092

C:/My Documents/ AD doc A-4doc

2.

2. Холбогдох зорилт, арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах;

Гурав. Мэргэжлийн хяналтын газарт:

1. Хөтөлбөрүүдэд туссан холбогдох зорилт, арга хэмжээг жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлэх;

2. Хог хаягдлын болон агаарын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор жил бүр хяналт шалгалтын чиглэлээр аян зохион байгуулах;

Дөрөв. Цагдаагийн газарт:

1. Хоггүй цэвэр Алтай хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж, бусад хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудтай хамтран ажиллах;

2. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, илэрсэн зөрчлийг арилгуулж, хуулийн дагуу хариуцлага тооцох;

Тав. Ус, цаг уур, орчны шинжилгээний газарт:

1. Агаар, ус, хөрсний хяналт шинжилгээний ажлыг чанаржуулж, дүн мэдээг иргэд олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах;

Зургаа. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг жил бүрийн 06, 12 дугаар сарын 10-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга, албан байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

Долоо. Албан даалгаварын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ч.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ